

## ГАРЧИГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл .....	3
1.2. Уурхайн жилийн хүчин чадал ба ажиллах горим, ашиглалтын хугацаа .....	5
1.3. Уурхайн барилга байгууламж, дэд бүтэц.....	7
1.4. Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө.....	7
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	8
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ .....	9
3.1 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тухай ерөнхий удирдамж.....	9
3.2 Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим .....	9
3.3 Гол сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим.....	12
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	13
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	14
4.2. Уурхайн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	17
4.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	17
4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	17
4.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	18
4.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	18
4.7. Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал.....	19
4.8. Тухайн жилийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр .....	20
4.9. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө.....	21
4.10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршиин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваары .....	21

## ХҮСНЭГТИЙН ГАРЧИГ

Хүснэгт 1. Ашиглалтын системийн үндсэн хэмжигдэхүүнүүд .....	5
Хүснэгт 3. Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл .....	9
Хүснэгт 4. Төслийн байришил, шийдвэр, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон нөлөөллийн эрчим, үр дагаврыг магадлан жагсаах .....	11
Хүснэгт 5. Байгаль орчинд узүүлэх болзошгүй нөлөөлөл .....	12
Хүснэгт 6. Гол сөрөг нөлөөлөл .....	12
Хүснэгт 7. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал .....	14
Хүснэгт 8. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө .....	17
Хүснэгт 9. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	17
Хүснэгт 10. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө .....	17
Хүснэгт 11. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	18
Хүснэгт 12. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	18
Хүснэгт 13. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	19
Хүснэгт 14. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	20
Хүснэгт 15. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө .....	21
Хүснэгт 16. Төслийн төлөвлөлт, биелэлтийг тайлганах хуваарь .....	21


## ЗУРГИЙН ГАРЧИГ

Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байришил .....	4
--	---

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

<b>Төслийн нэр:</b>	“Сэргүүн цагаан” нэртэй хайлуур жоншны ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл	
<b>Төсөл хэрэгжүүлэгч:</b>	“Тэнүүн байгаль” ХХК. Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 5-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, Цайз зах, 108 тоот.	
<b>Төсөл хэрэгжүүлэх талбайн байришил:</b>	Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг дэвсгэрт харьялагдах ба тус сумын төвөөс баруун зүгт 16 км, төмөр замын Олон Овоот станцаас баруун урагш 13.5 км оршино.	
Талбайн солбицуулуд:		
	1. 45° 50' 01.61"	108° 55' 01.67"
	2. 45° 50' 01.61"	108° 54' 38.68"
	3. 45° 50' 21.6"	108° 54' 38.68"
	4. 45° 50' 21.6"	108° 55' 01.67"
<b>Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын хууль эрх зүйн хүчинтэй баримтуудын жагсаалт:</b>	Улсын бүртгэлийн гэрчилгээ	
	✓ Улсын бүртгэлийн дугаар:	9019016141
	✓ Регистрийн дугаар:	2582457
	✓ Улсад бүртгүүлсэн:	2006.12.25
	Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл	
	✓ Дугаар:	MV-008149
	✓ Олгосон огноо:	2007.01.29



Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байришил

## 1.2. Уурхайн жилийн хүчин чадал ба ажиллах горим, ашиглалтын хугацаа

### Уурхайн ашиглалтын горим

2023 онд уурхайн хэвийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах үүднээс доор дурьдсан технологийн шаардлагыг хангаж ажиллана. Доорхи авсан хэмжигдэхүүнүүдийг тусгасан дэвсгэр болон босоо, хөндлөн зүсэлт зургууд дээр ил уурхайн байгуулж ил уурхайн хүрээн дэх уулын цул, хүдэр болон хөрс хуулалтын хэмжээг тодорхойлсон ба зарим нөхцөлд мөргөцгөйн налуугийн хэмжээ нь хүдрийн биетийн уналын өнцөгөөр тодорхойлогдож байгаа.

Хүснэгт 1. Ашиглалтын системийн үндсэн хэмжигдэхүүнүүд

Д/д	Үндсэн хэмжигдэхүүнүүд	Хэмжих нэгж	Тоон үзүүлэлтүүд
1	Ил уурхайн гүн	м	40
2	Ил уурхайн амсрын урт	м	330
3	Ил уурхайн амсрын өргөн	м	120
4	Ил уурхайн хажуугийн өнцөг	градус	30 /9-47/
5	Хөрс хуулалтын ажлын доголын өндөр:	м	5-10
6	Хүдэр олборлолтын ажлын доголын өндөр	м	5
7	Доголын налуугийн хэмжээ	градус	60
8	Ажлын бус доголын аюулгүйн өргөн	м	1.5
9	Ажлын доголын аюулгүйн өргөн	м	1.5
10	Ил уурхайн улны хэсгийн хамгийн бага өргөн	м	12
11	Ил уурхайн улны хэсгийн хамгийн бага урт	м	78
12	Ажлын талбайн өргөн	м	25-35

### Уурхайн хөрс хуулалтын горим

Ашиглалт явуулахаар сонгон авсан талбайг улирал, сарын графикт оруулан дараах үе шаттайгаар уулын ажлыг явуулна. Тухайн жилийн уулын ажилд 1.2м3-ийн утгуурын багтаамжтай HYUNDAI-LC2900 маркийн экскаватор, 1м3-ийн утгуурын багтаамжтай DAEWOO Solar-220 маркийн экскаватор, 3м3-ийн утгуурын багтаамжтай ZL-50 маркийн утгуур ачигч, 1200-155мм-ийн цооног өрөмдөх ZL-100 маркийн өрмийн машин, 16м3-ийн тэвшний багтаамжтай HOWO маркийн автосамосвал, 81кВт хүчин чадалтай TY-120 маркийн бульдозер зэргийг ашиглахаар төлөвлөсөн.

- ✓ Бульдозероор хөрсийг түрж хуулах
- ✓ Бульдозероор өрөмдлөгийн талбайг тэгшлэн хад, чулуу, овоологыг зөөж тээвэрлэж зайлзуулах
- ✓ Өрмийн машинаар өрөмдөж тэсэлгээний бэлтгэл ажлыг хийх
- ✓ Өрөмдсөн цооногийг тэсрэх бодисын паспорт, зааврын дагуу тэсрэх бодисоор цэнэглэж тэслэх
- ✓ Тэсэлсэн хоосон чулуу, хаягдлыг, экскаватор болон бусад автотээврийн хэрэгслээр ачижж тээвэрлэн тусгай бэлтгэсэн талбайд буулгах
- ✓ Хөрсний хаягдлыг батлагдсан зураг, схемийн дагуу төлөвлөсөн талбайд овоолох
- ✓ Хөрсний хуулалтыг HYUNDAI-LC2900 маркийн экскаватороор гүйцэтгэн 20 тонны NORD BENZ-р тээвэрлэх
- ✓ Хөрс хуулалтын ажлыг уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан графикаар хийж гүйцэтгэх

Ашиглалтын систем нь дараах параметүүдээр тодорхойлогдоно. Үүнд:

- ✓ Хөрс хуулалтын мөргөцөгийн өндөр – 5 м
- ✓ Хүдрийн биетийн зузаанаас хамааран хүдэр олборлох мөргөцгийн өндөр нь – 5 м
- ✓ Горизонт дахь ажлын талбайн өргөн –25 м
- ✓ Хүдэр болон хөрсний налуугийн өнцөг – 55°
- ✓ Тээвэрлэлт хийгдэх зуравсын өргөн – 8 м
- ✓ Мөргөцөгийн өндрөөс хамаарах хамгаалалтын зуравсын өргөн –3 м
- ✓ Карьерийн үүсгэх мөргөцөгийн өнцгийн хэмжээ – 60°

### **Уурхайн ашиглалтын системийн сонголт**

Сэргүүнцагааны хайлуур жоншны уурхайд ил ба далд олборлолт явуулахаар төлөвлөгдөж ашиглалтын техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-д тусгасан. Уурхай нь захиалагчид нийлүүлдэг бага хүчин чадалтай жижиг уурхай юм. Уурхайн уул ажлыг өрөмдлөг тэсэлгээний ажлын тусламжтайгаар гүйцэтгэх ба тээвэрлэлттэй ашиглалтын системийг сонгон авч байгаа болно.

### **Уурхайн ашиглалтын горим**

Ашиглалт явуулахаар сонгон авсан талбайг улирал, сарын графикт оруулан дараахи горимын дэс дараалалаар уулын ажлыг явуулна. Үүнд:

- ✓ Хөрс хийгдсэний дараа нээгдсэн хүдрийн талбайг цэвэрлэж тэсэлгээний өрөм өрөмдөхөд бэлтгэнэ.
- ✓ Өрөмдлөг хийж гүйцэтгэсний дараа тэсэлгээний паспортын дагуу өрөмдлөг тэсэлгээний ажил явуулна. Өрөмдлөг тэсэлгээний ажлын хэмжээг “Өрөмдлөг тэсэлгээний ажил” бүлэгт тусгана.
- ✓ Тэсэлсэн хүдрийг экскаватороор олборлож ачааны машинд ачиж хүдэр ялгах талбайд буулгана.
- ✓ Буулгасан хүдрийг гар аргаар сортын хүдрийг ангилж ялгана.
- ✓ Ялгасан сортын хүдрийг автомашинд ачиж хэрэглэгчдэд хүргэнэ.

Уурхайн ажиллах горимыг уурхайн хүчин чадал, жилд гүйцэтгэх уулын ажлын хэмжээнээс хамааруулан захиалагч байгууллагаас өгсөн төсөл боловсруулах даалгаварт тусгагдсаны дагуу ил уурхай жилд ажиллах хоногийг дараах байдлаар тооцов.

✓ Жилийн нийт хоног	365 хоног
✓ Үндэсний баяр, ёслололын амралтын хоног	12 хоног
✓ Засвар үйлчилгээ, бэлтгэл ажил	39 хоног
✓ Цаг агаарын нөхцлийг тооцсон хоног	14 хоног
✓ Уурхайн жилд ажиллах хоног	300 хоног
✓ Хоногт ажиллах ээлжийн тоо	2 ээлж
✓ Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	12 цаг тус тус байна.

### **Хүдэр олборлолт**

2023 онд уурхайн жоншны хүдэр олборлолтын ажлыг хүдрийн С-1.3 биетийн зүүн жигүүрээс эхлэн явуулахаар төлөвлөв. Дараа нь хүдрийн С-1.2 биетэд шилжих замаар олборлолтыг шаталж явуулна.

Хүдрийн олборлолтыг БНХАУ-д үйлдвэрлэсэн KQG-100 DTH маркийн тэсэлгээний өрмөөр өрөмдөж тэсэлгээ явуулсны дараа БНСҮ-д үйлдвэрлэсэн DAEWOO SOLAR-220 маркийн урвуу утгуурт гидравлик экскаватороор хутгаж хүнд даацийн автомашинд ачиж хүдэр ялгах талбайд зөөвөрлөж буулгана. Уулын хүдэр ухалт-ачилтын ажил болон хөрс хуулалтын ажилд 1,2 м<sup>3</sup> шанаганы багтаамжтай HYUNDAI 2900 LC-3 экскаватор, бүхэллэг жонш ФК-75, хүдэр ачихад 3 м<sup>3</sup> шанаганы

багтаамжтай ZL-50 маркийн авто ачигч, уулын тээврийн ажилд 20 тн даацтай NORD BENZ маркийн автосамосвал, хүдэр тээвэрлэлтийн ажилд HOWO маркийн автосамосвал зэргийг тус тус ашиглана.

### **1.3. Уурхайн барилга байгууламж, дэд бүтэц**

#### **1.3.1. Уурхайн цахилгаан хангамж**

##### **Уурхайн цахилгаан хэрэглэгчид ба эрчим хүчний үүсгэвэр**

Уурхайн цахилгаан хэрэглэгчдийг төвлөрсөн цахилгаан хангамжаас эрчим хүчээр хангах боломжгүй учир дизель цахилгаан үүсгүүрээс цахилгаан эрчим хүчээр хангахаар төсөлд тусгасан. Сэргүүнцагааны ил уурхайд одоо ашиглаж байгаа 100кВт-ын 1 ширхэг, 200кВт-ын 1 ширхэг дизель станцаас тус тус цахилгаан эрчим хүчээр хангана.

#### **1.3.2. Уурхайн гэрэлтуулэг**

*Ил уурхай, хүдэр ялгах хэсэг болон овоолгын цахилгаан гэрэлтуулэг:* Ил уурхай, хүдэр ялгах хэсэг, овоолго нь харьцангуй талбай багатай тул ПКН-1500 маркийн гэрэлтүүлгийн төхөөрөмжийг ашиглахаар сонгон авсан.

Уурхайн цахилгаан хангамжийн систем реле хамгаалалтын шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байх ба хамгаалалтын газардуулгын нийт эсэргүүцэл газрын дээр 4 Омоос хэтрэхгүй байна.

### **1.4. Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө**

2023 оны төлөвлөлтөөр 1, 2, 3-р хүдрийн биетүүдэд ил уурхайн аргаар олборлолтын ажил хийж гүйцэтгэх ба 1-р хүдрийн биетийн ил уурхайн ашиглалт дууссаны дараа далд уурхайн олборлолт хийхээр тооцлоо. Харин 2 болон 4-р хүдрийн биетэд далд уурхайн үндсэн малталтуудыг нэвтрэхээр төлөвлөлөө. Ил уурхайгаар 2023 онд 1-р хүдрийн биетээс 21.04 мян.тн, 2-р хүдрийн биетээс 22.95 мян.тн, 3-р хүдрийн биетээс 6.01 мян.тн хүдэр олборлохоор, далд уурхайгаар 1-р хүдрийн биетээс 12.4 мян.тн хүдэр олборлохоор тооцлоо.

Нийт олборлосон 62.435 мян.тн хүдрийг гар аргаар ангилан ялгаж 9.5 мян.тн ФК-65 маркийн бүхэллэг жонш гарган авч экспортлох ба үлдэгдэл бага агуулгатай хүдрийг дотоодын баяжуулах үйлдвэрүүдэд борлуулахаар тооцлоо.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Орд газар байршиж байгаа талбай нь Хэнтийн уулархаг ба говийн мужийн завсрын бүсэд хамаарна. Газрын гадаргуу нь далайн тувшиингээс дээш 900-1210м-т өргөгдсөн байдаг.

Гадаргуугийн рельеф нь гол төлөв толигор, мөлгөрдүү дов толгод юм. Ордын төвийн хэсгээр дайрсан цахирын судал ба цахирын бүс нь 0,8-1,05м-ийн өндөр хадан цохио үүсгэсэн байдаг. Ордын ойролцоо 2,0-7,0 км-ийн радиуст байрлах хужирлаг цайдам хөндий нь алсуур налуу заримдаа намгархаг, дэрснийх сондуулаар хүрээлэгдсэн байдаг.

Цайдам, хуурай нурууд нь бороо хур багатай зун, намрын цагт цагаан хужир шүүгээр бүрхэгдсэн байдаг. Эдгээр цайдамуудад Зайрмаг, Хужирт, Жаргалантын хөндийнүүд хамаарна. Эдгээр хөндийд нь Зайрмаг, Жаргалантын худаг байдаг ба худгаас жилийн дөрвөн улиралд хүн мал ундаалж байдаг.

Ордын ойр орчимд амьтан тун ховор, байгаа амьтад нь гол төлөв тарвага, туулай, зараа, алаг даага, гүрвэл болно. 2003 оноос өмнө тарвага нилээд байсан боловч сүүлийн 2 3 жилд тарвагыг их хэмжээгээр агнаснаас одоо тарвага бараг үзэгдэхээ больсон.

Хөрс ургамлын бүтэц нь өөрийн тархалт, зузаанаараа харилцан адилгүй. Талбайн хэмжээнд хүрэн, цайвар хүрэн, нам дор газарт цайвар шаргал, хужирлаг, толгодын эл хажуугаар хүрэвтэр өнгийн хөрсүүд ялгагдана. Хүрэн, хүрэн бор хөрс нь голдуу элсэнцэр агуулах ба хужирлаг цайвар шаргал хөрс нь аллювиаль, нуурын гаралтай шавар, шавранцараас тогтоно.

Шимт хөрсний үеийн зузаан нь 0,05-0,2м, хааяа 30-40 см хүртэл хэлбэлзэнэ. Нутаг дэвсгэрийн хэмжээнд ургамлын тархац маш сийрэг, хонхор хотгор газрууд толгодын хажуу бэл хэсэгт хур борооны дараа газар нь сэргэж ургамлын тархац ихэсдэг. Ургамлын бүрхэвч бүрдүүлэгч нэр төрлийн өвс ургамал нь хягана агь таана, хөмөл, шарилж зэрэг болно. Дов толгодын нуруу хажуу хэсгээр алтан харгана, дээр цайдам хөндийн хэсэгт бударган, дээрс ургадаг. Нутаг дэвсгэр нь бүхэлдээ эх газрын эрс тэс уур амьсгалтай бүсэд багтана. Ажиглалтаас үзэхэд улирал, сар, хонгийн температур нь эрс хэлбэлздэг, хур тундас бага, хуурайвтар байдаг. Сарын хамгийн бага дундаж температур нь 1-р сард - 12°C-25°C, хамгийн өндөр дундаж температур нь 7-р сард +20°C +22°C байдаг. Дулааны улиралд 9 сарыг дуустал үргэлжилдэг. Хур тундас бага унадаг, жилд дунджаар 160-180 мм хурдэг. Үүний ихэнх хэсэг нь зуны улирлын сүүлч, намрын эхээр бороо ордогтой холбоотой ба өвөлд дунджаар 23-27 мм хур тундас унадаг. Эх газрын баруун хойноос чиглэлтэй салхи зонхилно. Салхины хурд 2,8-7,3 м.сек хүртэл хурдасч шороон ба цасан шуурга шуурч хүчтэй салхилдаг.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

### 3.1 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тухай ерөнхий удирдамж

“Тэнүүн байгаль” ХХК-ийн “Сэргүүн цагаан” нэртэй хайлуур жоншны ордыг ил ба далд уурхайн аргаар ашиглах” төслийн хувьд байгаль орчны төлөв байдал, байгаль орчны эрх зүйн байдал зэрэг нь байгаль орчныг хамгаалах асуудалтай хэрхэн уялдах, төслийн үйл ажиллагаанаас хамрах нутаг дэвсгэрийн орчны бүрдэл хэсгүүдэд төслийн хэрэгжих үе шат бүрийн үйл ажиллагааны нөлөөлөл, түүнчлэн төслийн гол нөлөөллийг үнэлэн тогтоов.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, байгаль орчны эрх зүйн баримт бичгүүдэд тулгуурлан магадлан жагсаах, давхцуулан зураглах, загварчлалын арга, харьцуулсан судалгааны арга, БОНХЯ-аас /хуучин нэрээр/ гаргасан Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний аргачилсан заавар /2014/, байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд өргөн хэрэглэгддэг матриц зэргийг ашиглан хийж гүйцэтгэлээ.

### 3.2 Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим

Хүснэгт 2. Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Үргт хугацааны	Будаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
<b>1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт</b>										
Газрын доорх урсацын өөрчлөлт										
Газрын доорх усны чанарын өөрчлөлт										
Гадаргын усны өөрчлөлт										
Агаарын чанарын өөрчлөлт	x				x		x	x		
Ургамлын бүтцийн өөрчлөлт	x				x		x		x	
Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x		x	x		
Геологийн тогтоцын өөрчлөлт	x				x		x		x	
Зэрлэг амьтдын орон зай		x			x		x			x
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт		x			x					x
<b>2. Байгалийн нөөц, ашиглалт</b>										
Газрын гадаргын нөөц баялаг										
Бэлчээрийн байдал		x			x		x			x
Эрдэс түүхий эдийн нөөц	x				x		x	x		
Эрчим хүчний нөөц										
<b>3. Байгаль, орчны өөрчлөлт</b>										
Үндны усны чанар, хэмжээ										
Урсгал усны хэрэгцээ										
Агаарын бохирдол	x				x		x	x		
Хөрсний эвдрэл, бохирдол	x				x		x		x	
<b>4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор</b>										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	x				x		x		x	
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x				x		x		x	

Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх										
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх										
<b>5. Эдийн засаг, нийгмийн асуудал</b>										
Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	x				x		x		x	
Орон нутгийн орлого нэмэгдэх	x				x		x	x		
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	x				x		x		x	
Ажлын байр нэмэгдэх	x				x		x		x	
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	x				x		x		x	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх	x				x		x		x	
<b>6. Бусад нөлөөлөл</b>										
Шороон зам, шилжилтээс болж хөрс эвдрэх	x				x		x		x	
Ахуйн хаягдал, хогийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих	x			x			x		x	
Хүчтэй салхи, уруйн үер										
<b>Дүн</b>	<b>17</b>	<b>3</b>		<b>1</b>	<b>19</b>		<b>19</b>	<b>5</b>	<b>6</b>	<b>9</b>

Дээрх хүснэгтээс дүгнэхэд байгаль орчинд нөлөөлж болзошгүй шууд, урт хугацааны, буцалтгүй, бага зэргийн нөлөөлөл нилээд хувийг эзэлж байна.

Үүнд:

- ✓ Агаарын чанарын өөрчлөлт
- ✓ Ургамлын бүтцийн өөрчлөлт
- ✓ Хөрсний элэгдэл эвдрэл
- ✓ Уур амьсгалын өөрчлөлт
- ✓ Агаарын бохирдол
- ✓ Хөрсний элэгдэл, бохирдол
- ✓ Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх
- ✓ Орон нутгийн орлого нэмэгдэх
- ✓ Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох
- ✓ Ажлын байр нэмэгдэх
- ✓ Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх
- ✓ Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх
- ✓ Шороон зам, шилжилтээс болж хөрс эвдрэх
- ✓ Ахуйн хаягдал, хогийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах шавьж үржих зэрэг байна.

Дээрх болзошгүй нөлөөллүүдээс харахад эдийн засаг, нийгмийн асуудалд уурхайн үйл ажиллагаа шууд, урт хугацааны, буцалтгүйгээр нөлөөлөх эерэг нөлөөтэй байна.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тогтоох зорилгоор шинжээчдийн хэсэг газар дээр нь очиж, төсөл хэрэгжих талбай болон орчны байдал, ТЭЗҮ-тэй танилцаж, холбогдох судалгааг хийсэн болно.

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо **магадлан жагсаах** аргыг ашиглаж, үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал "x"-ээр тэмдэглэдэг.

Уг төслийн байршил, техник технологийн шийдэл болон төсөл хэрэгжих үеийн байгаль орчны асуудлыг тусад нь авч үзэн “магадлан жагсаалт” хүснэгтэнд түүний нөлөөллийн үр дагаврыг “муу”, “дунд”, “сайн” гэсэн утгуудын аль тохирохыг “х” гэж бөглөв.

*Хүснэгт 3. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон нөлөөллийн эрчим, үр дагаврыг магадлан жагсаах*

Нөлөөлөл байхгүй	Гол үр дагавар		
	Муу (бага)	Дунд	Сайн (иХ)
<b>Байгаль орчны асуудлууд</b>			
<b>1. Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал</b>			
Хүн амыг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудал	x		
Түүх соёлын дурсгалт газар, археологи-палентологийн олдворт газрыг эвдэхэд хүрэх	x		
Усан хангамж, газрын доорх усны горимд өөрчлөлт орох	x		
<b>2. Төслийн шийдэл, төлөвлөөгөөтэй холбоотой байгаль орчны асуудал</b>			
Үйл ажиллагааны болон ашиглалтын чанар нь тухайн орон нутагт нийцтэй эсэх, орчны бохирдлын хяналтын сонгосон төхөөрөмж хир зэрэг зохимжтой			x
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчинөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг хорт хий, гол түймрээс хамгаалах асуудал хир зэрэг төлөвлөгдсөн		x	
Уурхайн үйл ажиллагааны явцад гарах тоосжилтыг бууруулах асуудал хир зэрэг тусгагдсан			x
Тусгай анхаарал тавих шаардлагатай хорт хий, тоос, утая гардаг эсэх	x		
Үйл ажиллагааны үед гарах дуу чимээг багасгах талаар тосолд тусгагдсан эсэх		x	
<b>3. Барилга байгууламж барих, үйлдвэрийн аюулгүй ажиллагаатай холбогдож гарах байгаль орчны асуудал</b>			
Төслийн үйл ажиллагааны үед усны нөөц хомсдох байдал		x	
Төсөл хэрэгжих үеийн хөрсний элэгдэл, эвдрэл			x
Үйлдвэрлэлийн осол, аваар, хортой нөхцөл үүсэх, халдварт өвчин гарах нөхцөл			x
<b>4. Төсөл хэрэгжүүлэх үеийн байгаль орчны асуудал</b>			
Төслийн үйл ажиллагааны болон ашиглалтын чанарын талаарх төлөвлөгөө, санхүүжилт хир зэрэг бодитой, шаардлага хангасан эсэх			x
Мэргэжлээс шалтгаалах өвчин болон аюулгүй ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилт бодитой эсэх			x
Хөрсний эвдрэл, элэгдлийг бууруулах, орчныг тохижуулах асуудал төлөвлөгөөнд хэрхэн тусгагдсан (хөрсжүүлэх, ургамал тарих, зүлэгжүүлэх, талбайн усалгаа)			x
Шуурхай хяналтын асуудал (төсөлд шуурхай хяналтын хугацаа, мөнгө зардал тусгагдсан эсэх)		x	
<b>5. Төслийг өөрчлийн нь хянаж үзэх шалгуурууд (бодлогын чанартай асуудлууд)</b>			
Төслийн техник технологийн шийдлийг техник эдийн засгийн хувьд болон хувилбарас авч үзэн аль болох оновчтой аргыг сонгосон эсэх асуудал			x

#### *Төслийн байршилтай холбогдох нөлөөлөл*

Төсөл хэрэгжих байршилын хувьд хүн амыг нүүлгэн шилжүүлэх, түүх соёлын археологийн олдворт газарт ямар нэгэн нөлөөлөл байхгүй.

#### *Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой асуудал*

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчинөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг хорт хий, гол түймрээс хамгаалах асуудал, мөн үйл ажиллагаанаас гарах дуу чимээг багасгах талаар дунд зэргийн үр дагавартай байна.

## Төслийг хэрэгжүүлэх үеийн байгаль орчны асуудал

Төслийг хэрэгжүүлэх нийт ажлын явцад байгаль орчинд хөрсний элэгдэл эвдрэл, газар ашиглалтанд хохирол учруулах зэрэг нөлөөлөл хүчтэй байна.

### 3.3 Гол сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим

“Сэргүүн цагаан” нэртэй хайлуур жоншины ордыг далд уурхайн аргаар ашиглах төслийн хүрээнд хайлуур жонш олборлох, гар аргаар ангилан ялгах, тээвэрлэх үйл ажиллагаанууд хийгдэнэ. Ийм далд уурхайн байгаль орчны сөрөг нөлөөллийн асуудлыг авч үзэхдээ Леопольдын матрицын аргыг хэрэглэв.

Хүснэгт 4. Байгаль орчинд узүүлэх болзошгүй нөлөөлөл

№	Үйл ажиллагааны хэлбэр Экологийн тогтолцоо	Эрэл хайгуул	Хөрс хуулах (хөгжлийн барилга, сайнүүдэлж)	Тэсэлгээ	Далд уурхайн нэвтрэлт	Гар аргаар ангилан ялгах	Овоолго	Ачих тээвэрээдийн хувь	Бүгд
1	Агаар		2/3	9/9	2/2	8/8	3/3	4/5	28/30
2	Хөрс		2/5	10/10	3/3	3/3	6/6	2/3	26/30
3	Гадаргын ус								
4	Газрын доорхи ус								
5	Ургамал		5/5	9/9	3/3	3/3	8/8	2/3	30/31
6	Ан амьтан		1/1	1/1				1/3	3/5
7	Усны амьтан, ургамал								
8	Геологийн тогтоц		1/1	9/9	8/8			1/1	19/19
9	Байгалийн үзэсгэлэн		1/1	5/5	2/2	1/1	1/1		10/10
10	Бэлчээр		2/2	5/5	3/3	4/4	6/6	1/1	21/21
11	Хүний эрүүл мэнд		5/6	4/5	9/9	8/8	1/2		27/30
12	Бүгд		19/24	52/53	30/30	27/27	25/26	11/16	164/176

Дээрх хүснэгтийн босоо багануудын нийлбэр дүнгээс үзвэл хөрс хуулах, тэсэлгээ хийх, нүх, карьер ухах, овоолго хийх, ачих тээвэрлэх явц нь агаар, хөрс, ургамал, хүний эрүүл мэнд зэрэгт ихээхэн нөлөөлж болзошгүй нь харагдаж байна.

Нөлөөлөлд хамгийн их өртөгч нь агаар, хөрс, ургамал зэрэг юм.

Нөлөөлөлд орох байдлаар ангилбал агаар 28/30, ургамал 30/31, хөрс 26/30, бэлчээр 21/21, хүний эрүүл мэнд 27/30 1-р ангилалд, геологийн тогтоц 19/19, байгалийн үзэсгэлэн 10/10 2-р ангилалд орж байна. Иймд 1 ба 2-р ангиллын өртөгчдөд нарийвчилсан судалгаа, тооцоо хийх нь зүйтэй.

Хүснэгт 5. Гол сөрөг нөлөөлөл

№	Байгаль орчны хүчин зүйлс	Гол сөрөг нөлөөлөл	
		Гол сөрөг нөлөөлөл	Гол сөрөг нөлөөлөл
1	Газрын гадарга, хөрс	Уурхайн үйл ажиллагаа болон овоолгоор хөрс, ургамал нь бүр мөсөн устаж, дахин сэргээгдэхгүйгээр үхжинэ.	
2	Агаар	Хайлуур жоншийг ачих, тээвэрлэх, овоолго үүсгэх зэрэг үйл ажиллагааны үед агаарын чанарт үзүүлэх нөлөө их байна. Энэ үед тоос, тээврийн хэрэгслээс гарах ШТМ-ын утас агаарт дэгдэж серөг нөлөө үзүүлж болзошгүй.	
3	Ургамал	Нийт талбайн ургамлан бүрхэвч устаж үгүй болно. Нөхөн сэргээгдэх байдал хязгаарлагдмал. Овоолго үүсгэх газрын ургамал мөн устаж үгүй болж ургамлын бүрхэвчийн хэмжээ, бэлчээрийн талбай багасна. Ургамлын нөхөн сэргээгдэх боломжийг судалж, хаягдал хаягдаагүй хэсгүүдийг нөхөн сэргээх шаардлагатай.	

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### *Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго.*

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, арилгах, төсөл хэрэгжих орчинд үүсэж болзошгүй сөрөг үр дагаврыг тогтмол хянах зорилготой. Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр дараахь арга хэмжээг хэрэгжүүлэхийг зорино.

Үүнд:

- ✓ Уурхайн үйл ажиллагаанд хамрагдаж байгаа талбайн хэмжээнд байгаль орчны хуулийн нийцлийг хангах,
- ✓ БОНHYнэлгээний заалтуудыг хэрэгжүүлэх,
- ✓ Байгаль орчны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хамаарал, хамрах хүрээг тодорхойлох,
- ✓ Уурхайн үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудын үйл ажиллагаандаа баримтлан хэрэгжүүлэх байгаль орчны асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг тодорхойлох,
- ✓ Орон нутгатай байгаль хамгаалах, дүйцүүлэн хамгаалах ажилд хамтран ажиллах,
- ✓ Талуудын оролцоог хангах, ОХШХ-т олон нийтийн оролцоог хамруулах, тайлагнах тогтолцоог сайжруулах,

#### 4.1. Сөрөг нөлөөлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 6. Сөрөг нөлөөлийг бууруулах арга хэмжээний зардал

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөлийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөлийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
<b>Агаар орчин</b>									
1	Уурхай орчимд тоосжилт үүсэх	Уурхайн ам орчимд болон тээврийн гол замыг чийгшүүлэх, услах, дагтартшуулах	Уурхайн гол болон тээврийн зам	км	25.0	1.6	40.0 x 25 удаа = 1 000.0	Зуны хуурай улиралд 7 хоногт 2 удаа	MNS 4585:2007” “Гадаад орчны агаарын түгээмэл бохирдуулагчийн хүлцэх агууламж болон зөвшөөрөгдх түвшин стандарт MNS 5916:2008
2		Жил бүрийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу агаар, орчин дахь тоосны хэмжээг тодорхойлж байх	Уурхай орчим, тээврийн гол зам дагуу	ш	100.0	2	200.0 /ОХИХ/	Жилд 2 удаа	
<b>Гадаргын ба газрын доорхи усны нөөц</b>									
1	Ашиглаж буй усны чанар муудах, хүрэлцээ бага байх	Ус ашиглах дүгнэлтийг жил бүрийн эхэнд гаргуулах	Уурхай	Үйл ажиллагааны зардлаас				Жил бүрийн эхэнд	Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль “Усан орчны chanaryn үзүүлэлт” MNS 4586:1998.
2		Ус ашигласны төлбөрийг цаг тухайд нь тогтмол хугацаанд төлөх		Үйл ажиллагааны зардлаас				Үйл ажиллагааны турш	
3		Үнд, ахуйн хэрэглээний усанд тогтмол шинжилгээ хийлгэж байх	Гүний худаг	ш	50.0	4	200.0 /ОХИХ/	Улиралд 1 удаа	
<b>Хөрсон бүрхэвч</b>									
1	Төслийн үйл ажиллагааны явлад ихээхэн талбайн хөрс овоолго, уурхайн тосгон, бусад байгууламжуудын дор дарагдаж, элэгдэл, эвдрэлд өртөнө.	Овоолго болон бусад байгууламжуудыг байгуулахын өмнө өнгөн хөрсийг хуулан авах,	Овоолго	Үйл ажиллагааны зардлаас				Ашиглалтын явлад	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай Монгол улсын хууль MNS 5914:2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. MNS 5916:2008 “Газар шорооны
		Хуулж авсан өнгөн хөрсийг тусгайлан овоолго байгуулан хадгалах	Шимт хөрсний овоолго						

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллиүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
2	Уурхайн замын ачааллаас хөрс элэгдэж, эвдрэлд орох	Хүнд машин механизм явах замыг засаж сайжруулан, байгалийн хөрс бүхий замаар тээвэрлэлт аль болох бага хийх	Уурхай орчим, тээврийн гол зам дагуу						
<b>Газрын хэвлэй</b>									
1	Жонш олборлосоноор газрын хэвлийд хоосон орон зай шинээр үүсгэнэ.	Уурхайн малталтууд болон олборлосон орон зайд бэхэлгээ, хамгаалалтын цул зэргийг үлдээж нуралт үүсэхээс сэргийлнэ	Ил уурхай	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан зардлаар				Ашиглалтын явшад	MNS 5916:2008 “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт” MNS 5917:2008 “Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” стандартууд
<b>Ургамлан номрог</b>									
1	Уурхайгаас олборлосон жонш ялгах, хоосон чулуулгийн овоолго үүсгэх зэрэг ажлын үед ургамал устах, дарагдах, талахлагдах зэргээр хамгийн их нөлөөлөлд өртөнө.	Нөхөн сэргээлтэнд ашиглах хөрсний шимт хэсгийн овоолтыг стандартын дагуу тусгайлан овоолж, салхинд хийсэхээс хамгаалах.	Шимт хөрс, овоолтын талбай	Ашиглалтын зардлаар				Ашиглалтын явшад	MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт. Хадгалалт MNS5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн сөрөнхий шаардлага
3		Уурхайн тосгон орчимд ногоон байгууламж бий болгох	Уурхайн тосгон	III	20.0	50	1 000.0 /Нөхөн сэргээлтийн зардлаар/	10-р сард	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллиүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
<b>Амьтны аймаг</b>									
1	Амьтны аймагт хохирол учруулах, тоо толгой хородгох, идэш тэжээлийн хомсдол үүсэх	Мал амьтан өнгөрч гардаг хэсгүүдэд тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах, Авто машины хурдыг тогтоосон хязгаарт байлгах	Үйл ажиллагааны турш	Ашиглалтын зардлаас					
<b>2023 оны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардлын урьдчилсан дун</b>				<b>2 400.0</b>					
Амьтны тухай хууль: 6.1.3.амьтны хэвийн өсөлт үргжилтийг хадгалах, тархац нутгийг хамгаалах, нуудлийн замыг чөлөөтэй байлгах; 6.1.7.үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан устахаас урьдчилан сэргийлэх;									

#### 4.2. Уурхайн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хүснэгт 7. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих илгэж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Биологийн нөхөн сэргээлт	“Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөний хүрээнд уурхайн тосгон орчимд мод тарих	Ш	50	20.0	1 000.0 /Үйл ажиллагааны зардлаар/	2023 онд	
2	Татан буулгах, хаалтад бэлтгэх	-	-	-	-	-	-	-
Нийт						1 000.0		

#### 4.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 8. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Биологийн нөхөн сэргээлт хийх	Биологийн нөхөн сэргээлт	“Нөхөн сэргээлт-2024” арга хэмжээний хүрээнд Баянжаргалан суманд биологийн нөхөн сэргээлт хийх	100	20.0	2 000.0	2023 онд	MNS 5917:2008 “Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” стандартууд
	Нийт					2 000.0		

#### 4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 9. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1		2023 онд нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөгдөөгүй.						

#### 4.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 10. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Археологийн дурсгал		Уурхай орчимд археологийн дурсгал илрээгүй болно.					
2	Палеонтологийн дурсгал		Уурхай орчимд палеонтологийн дурсгал илрээгүй болно.					

#### 4.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 11. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Гал түймэр	Аваар устгах төлөвлөгөө боловсруулах	Уурхай	1	Үйл ажиллагааны зардлаас	2023 онд		
2	Тэсрэх бодис	Мэргэжлийн гэрээт байгууллагаар тэсэлгээний ажил гүйцэтгүүлэх  Тэсрэх бодисын тоо бүртгэлийг тогтмол хийх  Тэсрэх бодисын үлдэгдэл, сав баглаа боодлыг гүйцэтгэгч компанийтай гэрээ байгуулан аюулгүй болгох	Тэсэлгээний ажлын үед	Aшиглалтын зардлаас	Ил уурхайн аюулгүй ажиллагааны нийтлэг дүрэм	MNS 4223 : 1994 Тэсрэх бодис Техникийн шаардлага		

#### 4.7.Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал

Хүснэгт 12. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангиалал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн	Хог хаягдлыг түр хадгалах цэгийг тохижуулах	Уурхай	ш	200.0	1	300.0	4-р сар	Хог хаягдлын тухай хууль
		Хог хаягдлын гэрээ байгуулж, тогтмол тээвэрлүүлэх	Уурхай	сар	50.0	6	300.0	4-10-р сар	
2	Үйлдвэрийн	Хоосон чулуулгийн овоолго үүсгэн хадгалах	Уурхай					2023 онд	
3	Аюултай	Тэсрэх бодисын сав баглаа боодлыг гүйцэтгэгч компанийд хүлээлгэн өгөх	Уурхай					2023 онд	
Нийт					600.0				

#### 4.8. Тухайн жилийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд агаарын чанарын болон дуу шуугианы хэмжилт хийх, хөрсний болон усны шинжилгээ хийлгэх ажлыг төлөвлөсөн бөгөөд уг ажлыг гүйцэтгэх явцдаа нөлөөллийн бүсийн иргэд, орон нутгийн төлөөллийг байлцуулах шаардлагатай.

*Хүснэгт 13. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр*

Хяналт-шинжилгээ хийх узүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Зардал, мян.төг/жил	Баримтлах стандарт ба арга, аргачлал
<b>Агаарын чанар</b>				
SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> , CO, Тоос,	Уурхайн амууд, гол зам, тосгон орчим 3 цэгт	Жилд 2 удаа, хавар, намар	400.0	MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
Агаар бохирдуулагч бодисуудын ялгарлын хэмжээ	Ашиглагдаж буй тээврийн хэрэгслүүд	Жилд 1 удаа	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардлаас	MNS 5013:2003 Бензин хөдөлгүүртэй автомашин, утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5014:2003 Дизель хөдөлгүүртэй
<b>Дуу шуугиан</b>				
Дуу шуугиан, чичиргээ	Уурхайн талбай, тоног төхөөрөмж, ажлын байранд 3 цэгт	Жилд 2 удаа, хавар, намар	200.0	MNS4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 5002:2000 Шуугианы норм, аюулгүй ажиллагаа
	Авто тээврийн зам дагуу	Жилд 2 удаа, хавар, намар		MNS4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
<b>Хөрсөн бүрхэвч</b>				
Хөрсний нефть бүтээгдэхүүний бохирдол	Уурхайн гол зам, тосгон орчим 2 цэгт	Жилд 1 удаа	200.0	MNS 3473:1983 Газар. Газрын эдэлбэр. Газар ашиглалт. MNS 3297:1991 Хот суурин газрын хөрсний ариун Ариун цэврийн үнэлгээний узүүлэлтийн норм хэмжээ
<b>Усан орчин</b>				
Үнд ахуйн зориулалтгаар ашиглах усны pH, TDS, нийт хатуулаг, исэлдэх чанар, Ca, Mg, Na, K, NH <sub>4</sub> , нийт Fe, HCO <sub>3</sub> , Cl, SO <sub>4</sub> , NO <sub>2</sub> , NO <sub>3</sub> , амт, үнэр, онгө, тунгалаг чанар, эрдэсжилт г.м	Уурхайн үнд ахуйн хэрэглээний усыг авдаг худгаас	Жилд 1 удаа	200.0	MNS ISO 5667-1 : 2002 Усны чанар. Дээж авах 1-р хэсэг: Дээж авах хөтөлбөр боловсруулах заавар MNS ISO 5667-3 : 2019 Усны чанар. Дээж авах. 3-р хэсэг: Усны сорыцтой харьцах ба сорыцыг тогтвортжуулах
<b>Төслийг хэрэгжүүлэх эхний жилийн зардлын урьдчилсан дун</b>			<b>1 000.0</b>	

#### 4.9. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 14. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Үрьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар		
			2023 он						
			4-5-р сар	6-8-р сар	9-10-р сар				
1	Уурхайн бэлтгэл ажлыг бүрэн хангах	Үйл ажиллагааны зардлаар				Уурхайн дарга			
2	УАТөлөвлөгөө болон БОМТ-г боловсруулан батлуулах	-				Ашиглалтын инженер, БО-ны мэргэжилтэн			
3	БОМТ-нд тусгасан ажлуудыг хэрэгжүүлэх	БОМТ-ний зардлаар				Байгаль орчны мэргэжилтэн			
4	Ажилчдыг ХХАА-ны хувцас хэрэгслээр бүрэн хангах	Үйл ажиллагааны зардлаар				Уурхайн дарга			

#### 4.10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршиин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Хүснэгт 15. Төслийн төлөвлөлт, биелэлтийг тайлагнах хуваарь

№	Ажлын нэр	Хэнд	Хариуцах эзэн	Хугацаа	Зардал
1	Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө төсөл хэрэгжих талбайн өнөөгийн байдлыг танилцуулах	Дундговь аймгийн БОАЖГ, төслийн нөлөөллийн бүсийн иргэд	Уурхайн дарга, БО-ны мэргэжилтэн	V сард	1 000.0 мян.төг
2	Уурхайн үйл ажиллагааны тухай тайлан мэдээг орон нутгийн албан ёсны цахим хаягаар танилцуулах, иргэдийг мэдээллээр хангах	Төслийн нөлөөллийн бүсийн иргэд, сумын иргэд	Уурхайн дарга, БО-ны мэргэжилтэн	X сард	
3	Нийт хийгдсэн ажлын хэмжээ, хийгдсэн ажлуудын тайлagnal	Дундговь аймгийн БОАЖГ, төслийн нөлөөллийн бүсийн иргэд	Уурхайн дарга, БО-ны мэргэжилтэн	X сард	

2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 8.0 сая төгрөгийг төлөвлөж өглөө. Үүнд: Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардалд 2.4 сая төгрөг, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд 2.0 сая.төг, хог хаягдлын менежментийн арга хэмжээний зардалд 0.6 сая.төг, ОХШХ-т 1.0 сая төг, төслийн төлөвлөлт, биелэлтийг тайлагнах ажилд 1.0 сая.төг зарцуулахаар тооцсон болно.